

02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Аймгийн Засаг дарга М.Идэрбат энэ сарын 02-нд “Сүхбаатар хөгжил” Үйлдвэр технологийн парк, “Сүхбаатар Про импекс” оёдлын үйлдвэр, “Ойжуулалт-Усжуулалт сум дундын ойн анги” ОНӨҮГ, Ахмадын хороо зэрэг байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, холбогдох асуудлаар үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Аймгийн удирдлагуудаар ахлуулсан 6 ажлын хэсэг "Аймгийн аварга малчин" гэх хүндтэй шагналын эзэд болсон 33 малчинд хүндэтгэл үзүүлж, шагналыг гардуулав.

Аймгийн удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнийг Баруун-Урт хотноо 2021 оны 02 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Аймгийн Засаг дарга сургалт, зөвлөгөөний эхний өдөр сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, агентлаг, албадын дарга нарт аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан бодлого, чиглэл, зорилт, арга хэмжээний талаар танилцууллаа.

Зөвлөгөөний үеэр аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс болон агентлагийн дарга нар 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлого, шийдвэрүүдийг танилцуулж, цаашид анхаарах асуудал зэргээр сургалт хийсэн ба Авлигатай тэмцэх газраас цахимаар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өглөө. Сургалтын үеэр сумын Засаг дарга нар аймгийн Засаг дарга, Тамгын газрын хэлтсийн дарга, агентлаг, албадын дарга, холбогдох бодлого хариуцсан мэргэжилтнүүдээс асуулт асууж, тодруулга хийн, сум орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй асуудал болон цаашид анхаарах, хамтран ажиллах талаар ярилцаж санал солилцлоо. Тус сургалт, зөвлөгөөнд аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга, Хууль эрх зүйн мэргэжилтэн, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албадын дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлого хариуцсан мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй нийт 100 гаруй албан хаагчдыг хамрууллаа.

Сургалт, зөвлөгөөний төгсгөлд аймгийн Засаг дарга сумын Засаг дарга нартай 2021 онд хамтран ажиллах гэрээг байгуулсаны зэрэгцээ агентлаг, албадын дарга нарын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан баталгаажуулж гарын үсэг зурах арга хэмжээг зохион байгууллаа. Түүнчлэн аймгийн Засаг даргаар батлуулсан сумын Засаг дарга, Цагдаагийн газрын дарга, сумдын хэсгийн төлөөлөгч нартай 2021 онд хамтран ажиллах гурвалсан гэрээг байгууллаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: Агентлаг, сумдын 2020 оны үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолыг үндэслэн аймгийн засаг даргын 2017 оны 612-р захирамжаар баталсан “Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Аймгийн Засаг даргын 2020 оны А/620 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг аймгийн хэмжээний нийт 22 агентлаг, 5 төсөвт байгууллагын үйл ажиллагаанд 11 шалгуур үзүүлэлт, 13 сумын үйл ажиллагаанд 12 шалгуур үзүүлэлтээр тус тус хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн ба Удирдах ажилтны сургалт зөвлөгөөний үеэр 2020 оны үйл ажиллагааны үзүүлэлтээрээ тэргүүлсэн сумд, агентлаг, албад, төсөвт байгууллагыг шагнаж урамшуулав. Үүнд: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албадаас 2020 оны үйл ажиллагааны үзүүлэлтээрээ Нийгмийн даатгалын хэлтэс тэргүүлэв. Дэд байранд Боловсрол, соёл урлагийн газар, гутгаар байранд Цагдаагийн газар тус тус шалгарлаа. Сумдын хувьд Баруун-Урт сум тэргүүлж, дэд байранд Мөнххаан, гутгаар байранд Уулбаян сум шалгарсан байна.

Сүхбаатар аймгийн 2021-2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн зорилтод түвшинг бодлогын хэлтсүүдээс хүлээн авч болон улсын орон нутгийн бодлогын баримт бичигүүдтэй уялдуулан тодорхойлж ЗГХЭГ-т хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй 9 дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, ЗГХЭГ-ын unelgee.gov.mn цахим сайтад шалгуур үзүүлэлт тус бүрээр оруулж хугацаанд нь хүргүүлэв.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Архигүй Сүхбаатарчуудын төлөө” дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийсэн.

Төрийн албаны салбар зөвлөл: Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтын бүртгэлийн үйл ажиллагааг 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлүүлж 02 сарын 25-наар тасалбар болгон бүртгэлийг хаалаа. Төрийн албаны ерөнхий шалгалтад орохоор 264 иргэн бүртгүүлсэн байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2021 оны 2 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 6,870.4 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 1,134.5 сая төгрөгийн орлого орж нийт 8,004.9 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа. 2-р сарын байдлаар Улсын төсөвт 390.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 519.7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 132,9 хувиар, Орон нутгийн төсөвт 1,259.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,460,1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 115,9 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 873.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 7,316.4 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан.

13 төсвийн шууд захирагчийн 2020 оны 4 дугаар улирлын санхүүгийн тайланг шалгаж хүлээн авч дуусан сумын төвлөрүүлэн захирагчийн тайланг шалгах ажил хийгдэж байна.

2020 оны Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах хугацаа ковид-19 нөхцөл байдлаас шалтгаалан 2 сарын 26-ны өдрийг хүртэл сунгаж аймгийн хэмжээний нийт 916 ААНБ тайланг хүлээн авахаас 717 ААНБ буюу 79 хувь нь хуулийн хугацаандаа тайлагнасан байна.

Сумдын ОНХС-аар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, санхүүжүүлэх, өмчийн бүртгэлд авах, 2021 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаах заавар, зөвлөмжийг Сүхбаатар, Мөнххаан, Онгон суманд бүсчилж ХОХБТХ, ОНӨГ, ГХБХБГ, ТА-3 төслийн зохицуулагчтай хамтран зохион байгуулсан бөгөөд нийтдээ 100 гаруй албан хаагч оролцсон.

Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол гарсантай холбогдуулан төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж цалин, тэтгэврээс бусад зарлагыг эрэмбэ тогтоон санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллалаа.

Татварын хэлтэс: 2021 онд ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн тайланг цахимаар авч байгаатай холбогдуулан татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх нээлттэй утсыг иргэдэд зарлаж, утсаар болон емэйл хаягаар, ажлын байранд нь, хэсэгчилсэн, танхимаар татвар төлөгчдөд ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар заавар, зөвлөгөөг өгч ажиллалаа.

Орон нутгийн өмчийн газар: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар “Үндсэн хөрөнгө худалдах, шижлүүлэх, актлах” тогтоолын дагуу дуудлага худалдааг зохион байгуулж 3

хөрөнгийг худалдан борлуулж орон нутгийн төсөвт 11,350,000 төгрөгийг төвлөрүүлэх ёстойгоос 5,128,563 төгрөгийг төвлөрүүлж үлдсэн 6,221,437 төгрөгийг хуулийн хугацаанд багтаан төлөхөөр гэрээ байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан сумдад ажиллах удирдамжийн дагуу 2021 оны 02 сарын 18-22-ны өдрүүдэд 12 сумын ЗДТГ-ын холбогдох албан хаагчдад Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хүлээн авах, өмчийн бүртгэлд тусгах талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.

2021 оны 02 дугаар сард аймгийн Засаг даргын захирамжаар нийт 9 үнэлгээ хороо байгуулагдаж, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг tender.gov.mn сайтаар дамжуулан 02 дугаар сард 4 бараа, ажил, үйлчилгээний тендерийг нээж, 1 тендер шалгаруулалт амжилттай болж, 18,315,000 төгрөгөөр гэрээ байгуулах, эрх олгох зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. 7 тендерт шаардлага хангасан оролцогч ирээгүй тул дахин зарласан болно. Мөн 2 зөвлөх үйлчилгээний тендерийг 19,800,000 төгрөгөөр шууд гэрээ байгуулах, эрх олгох зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. Тендер шалгаруулалт амжилтгүй болсон 1 тендер, Үнэлгээ хийгдэж байгаа 1 барааны тендер байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг 2021 оны 01 дүгээр сарын 28-30 –ны өдрүүдэд цахим хэлбэрээр Сангийн яам, ХАА зөвлөгөө өгөх ТББ-тай хамтран зохион байгуулсан. Шалгалтыг 2021 оны 02 дугаар сарын 03-05 –ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулж, тус сургалтад нийт 135 иргэн шалгалт өгч одоогийн байдлаар 52 иргэн буюу 38 хувь нь тэнцсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Тус алба нь аймгийн Биеийн тамир, спортын газар, Насан туршийн боловсрол төв, Угсаатны зүйн музей, Нийтийн номын сан зэрэг газруудад Дотоод аудитын шалгалт хийж байна.

Статистикийн хэлтэс: Аймгийн нийгэм эдийн засгийн жилийн эцсийн 2021 оны 01 дүгээр сарын танилцуулгыг салбар бүрийн гол гол үзүүлэлтүүдээр нэгтгэн 2021 оны 02-р сарын 20-нд хэвлэн тархаан ажилласан.

ААНБ-ын үйл ажиллагаанд Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөллийн 1 дүгээр сарын судалгаанд 76 ААНБ-ыг бүрэн хамруулан ҮСХ-нд дамжуулсан.

Малчид тэтгэвэрт гарах ажилласан жилээ нөхөн тооцуулахтай холбогдуулж 2008-2019 оны малын А дансны мэдээлэлээ гаргуулах хүсэлтэй 8 иргэн өргөдөл өгснийг хугацаанд нь шийдвэрлэсэн.

2021 оны өрхөд суурилсан судалгааны 1-р сарын мэдээлэл цуглуулалтын ажлыг бүрэн дуусч судлаачаас ҮСХ-нд дамжуулсан, 2-р сарын мэдээлэл цуглуулалтын ажил явагдаж байна.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлагийн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсролын байгууллагуудын барилга, газрын талаарх дэлгэрэнгүй судалгаа, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох сургууль, цэцэрлэг, дотуур байруудын судалгааг гаргалаа.

Боловсрол, соёлын байгууллагуудын 2020 оны үйл ажиллагаанд чанарын болон тоон үнэлгээ шинжилгээ хийж, амжилттай ажилласан сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдийг шагнаж урамшууллаа.

3 сарын 1-ний өдрөөс аймаг, сумдын сургуулийн цэцэрлэгийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангаж 3 удаагийн цахим хурал онлайн сургалтуудыг зохион байгуулсан.

Монгол улсад Боловсролын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулан гаргах сэтгүүлд Сүхбаатар аймгийн боловсролын түүхийн талаар мэдээлэл бэлтгэж байна.

Элсэлтийн ерөнхий шалтгалтад бэлтгэх цахим сорил 7 судлагдахуунаар зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд мэргэжлийн багш нарын бүлгийг 17 судлагдахуунаар зохион байгуулан 3 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж 1-р улирлын хичээлийн агуулгын хоцрогдлыг аймгийн хэмжээнд нэгтгэн, 2-р улирлын хичээлээр хоцрогдол арилгах нэгдсэн төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Насан туршийн боловсрол төв, сумдын насан туршийн боловсролын төвийн цахим хуудсуудаар дамжуулан 1579 хүнд 3 төрлийн сургалт мэдээлэл олголоо.

Дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол нөхөн эзэмшиж буй сургуулийн насны 71 суралцагч, бага боловсрол эзэмших 18, суурь боловсрол эзэмших 32 суралцагчийн ТВ хичээл үзэлтэнд анхаарч, суралцагчидтай эргэх холбоотой ажиллаж байна. Гэрийн 2021-02-02-ноос 2021-02-05, 2021-02-22-ноос 2021-02-25-ны өдрүүдэд хийж, нийт 14 суралцагчийн хувилбарт хичээлийн даалгаварыг шалгах, нэмэлт даалгавар өгөх, эрсдэлийн үнэлгээний судалгаа гаргах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Соёл урлагийн байгууллагуудын 2020 оны үйл ажиллагааны статистик мэдээг хуулийн хугацаанд соёл, урлагийн газарт, аймгийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн сангийн мэдээллийг нэгтгэн Соёлын өвийн үндэсний төвд цахимаар хүргүүлсэн.

Угсаатны зүйн музей “Хүн чулуун хөргийн хуулбар хийх нь” төслийг Швейцарийн хөгжлийн агентлагт хүргүүлээд байна.

Хүн чулууны эвдрэл гэмтэл чулууны бүтцийн судалгаа хийгдэж байна.

Хөгжимт жүжгийн театр: Аймгийн ЗДТГ, BBS телевизтэй хамтран “Цагаан сар” баярын теле концертыг орон нутгийн телевиз болон “Бидний цөөхөн Монголчууд” телевизүүдээр гаргасан.

Морин хуурын сургалтад 10 хүүхэд, Ёочингийн сургалтад 2 хүүхэд, байгууллагын албан хаагчдаас 2 ажилтан хамрагдаж байна.

Эмэгтэйчүүдийн баярт зориулсан хүндэтгэлийн тоглолт болон Цэргийн баярт зориулсан “Мөрдөс дуулсан аялгуу”-4 тоглолтын бэлтгэл ажил хийгдэж байна.

Нийтийн номын сан: “Амар мэндийн баяр” гар зургийн уралдаан цахимаар зохиож байгуулж цэцэрлэгийн насны 17, ЕБС-ийн 1-3-р ангийн 25 хүүхдийн бүтээл нийт 42 хүүхдийн бүтээл хүлээн аваад байна.

Луй Брайлийн мэндэлсэний 212 жилийн ойд зориулан шүлгийн уралдааныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулан явуулж байна.

Лавлагаа ном зүйн үйлчилгээний хүрээнд цахим хуудсаар нэг сарын хугацаанд 3260 удаа пост оруулан ажилласан байна. 19768 хүн хандалт өгсөн мэдээтэй байна.

Тэмдэглэлт өдрүүдээр Д. Сүхбаатарын мэндэлсний ойд зориулсан цахим хэлбэрээр ном зүйн лавлагааны материал бэлтгэн оруулсан. Мөн Д. Сүхбаатарын амьдрал түүхэн замналын тухай мэдээллийг сурталчлан ажилласан. Нийтдээ 130 гаруй хүн хандалт өгсөн байна.

Цахим сэтгүүлийн нэг дэх дугаараар “Сониуч хүүгийн адал явдал” богино өгүүллэг, Шунуугийн Чулуунборын Хунгийн чуулга номоос “Салхийг байцаав”, “Чөмөг идвэл нусгай болно”, “Нүдгүй гөлөг”, Танин мэдэхүйн цувралаар “Багачуудын мэдэхийг хүсдэг 1001 газар” “Дэлхийн нууц” “Бороо” “Амьтдын тухай гайхалтай баримтууд” “Манай гаригийн амьтад” номын мэдээллийг тус тус оруулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2021 оны 02-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 635 иргэнээс эмэгтэй 314, бүртгэлтэй ажилгүй иргэн 453 иргэнээс, эмэгтэй 218 иргэн байна. 30 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 23 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 21 нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 8 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас та мэргэжлээ сонгосон уу баннер бэлтгэж байгууллагын цахим хуудсанд байршуулж ЕБСургууль, захирал, эрхлэгч, сургуулийн менежер нартай хуваалцав. Мөн бүртгэлтэй мэргэжилтэй ажил хайгч иргэдийн судалгааг гаргаж ажил хайж байгаа баннерийг байгууллагын цахим хуудсанд байршуулснаар зарын дагуу “Тал булгийн уурхай”-д уурхайн тоног төхөөрөмж засварчин, “Монгол даатгал”-д жолооч нарын мэдээллийг цахимаар хүргүүлээ. Цахимаар бүртгүүлсэн болон бүртгэлтэй ажил хайгч иргэдэд сул чөлөөтэй ажлын байрны саналыг танилцуулж 3 иргэнийг ажлын байранд зуучилсан.

Короно вирустэй холбоотойгоор “Иргэн та гэрээсээ ажил хайгчийн цахим бүртгэлд бүртгүүлэх боломжтой боллоо”. гэсэн ажил хайгчийн цахим анкетыг боловсруулж байгууллагын цахим хуудас болон аймгийн цахим зарын хуудсуудад байршуулж ажил хайгч иргэдийг бүртгэсэн.

Мөн ажлын байрны захиалгын бүртгэлийг цахимаар бүртгэх маягтыг хийж байгууллагын цахим хуудсанд байршуулж сул чөлөөтэй ажлын байрны мэдээллийг авч байна. Аймгийн хэмжээнд шинээр 150 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, идэвхгүй байсан 312 иргэний бүртгэлийг холбогдох мэргэжилтнүүд сэргээсэн.

Нийгмийн халамжийн талаар: 02 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 755,000.0 мян.төг, тэтгэмжинд 190.000.0 мян.төг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 130,000 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 36,000.0 мян.төг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөнд 89,000.0 мян.төг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 141,800 мян.төг санхүүжилтийг авч арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгоод байна.

2 дугаар сард аймгийн хэмжээнд 1248 өрхийн 5739 иргэний 70032.0 мян төгрөгийн санхүүжилтийг олгосон.

2021 онд хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах тендер зарлаж байгаатай холбогдпуулан 12 сумын 67 хүнсний дэлгүүрт нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.

Асгат, Баяндэлгэр, Түмэнцогт, Уулбаян, Наран, Мөнххаан, Онгон, Халзан, Түвшинширээ сумдын тендер шалгаруулалт явагдсан боловч Асгат, Баяндэлгэр, Түмэнцогт сумдаас бусад сумдын тендерийг дахин зарласан.

Одоогийн байдлаар Асгат сумын “Асгат дөхөм” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирсний дагуу аж ахуй нэгжид мэдэгдлийг хүргүүлсэн.

Алдарт эхийн одонгийн болон насны хишиг, ахмадын хүндэтгэл олгохтой холбоотой дансжуулах, нийгмийн халамжийн бусад үйлчилгээ авахаар биеэр ирж үйлчлүүлсэн болон лавлах утсаар нийт 2400 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг зохион байгуулж сум болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2020 оны үйл ажиллагаа тайланг хэлэлцэж 2021 онд баримтлах бодлого, хийгдэх ажлуудыг танилцуулж сумдын Засаг дарга, ЭМТ-ийн эрхлэгч нартай 3-ласан гэрээ байгууллаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанд мониторинг хийж үр дүнг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын лаборант нарыг Коронавируст халдварын сорьц авах, хадгалах, тээвэрлэх, халдвараас сэргийлэх чадавхи сайжруулах 2 хоногийн сургалтад хамруулж түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж байна.

Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн албаны гамшгийн төлөвлөгөөнд Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцооны хариу арга хэмжээг зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах хүний нөөц, хүч хэрэгсэлд тодотгол хийж Онцгой байдлын даргаар шинэчлэн батлуулж мөрдөн ажиллаж байна.

Улаанбаатар хотоос аймаг руу зорчих иргэдийг Коронавируст халдварын шинжилгээнд хамруулах зорилгоор Хэнтий, Сүхбаатар аймгийн нутгийн зааг "Давсан бадрах" гэх газарт шинжилгээний "Түр цэг" байгуулан 1184 зорчигч иргэнийг түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд, 31 иргэний PCR шинжилгээнд хамруулан сорьцыг Дорнод аймгийн бүсийн оношилгооны төвд тээвэрлэн шинжлүүлсэн. Мөн сумдад-24, Баруун-Урт-9 нийт 33 явуулын цэгт ажиллуулж нийт 2663 иргэнд түргэвчилсэн оношлуураар, 177 иргэнээс PCR шинжилгээ авч Дорнод аймгийн БОЭТ-д шинжлүүлж хариу сөрөг гарсан.

Коронавирус халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалтад зорилтот бүлгийн хүн амыг хамруулах бэлтгэл бэлэн байдлыг хангуулах шийдвэрийг аймгийн Засаг даргын шийдвэрээр батлуулан хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж сумдад арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Сүхбаатар аймагт өөр аймгаас болон өөрийн аймагт отор нүүдлээр яваа 3087 иргэний судалгааг авч эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх нэгдсэн чиглэлийг гаргаад байна.

Осол гэмтлээс сэргийлэх "Хором бүрээ анхааръя-2", "Унаж бэртэх гэмтлээс сэргийлэх" аяныг 1 сарын хугацаатай зохион байгуулж 14 төрлийн сургалтад 3181 хүнийг хамруулсан байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Цахим архивын үйлчилгээг хэрэгжүүлэн нийгмийн даатгалын QR кодтой лавлагааг 102 иргэнд, хэлтэс хоорондын 12 лавлагаа дамжуулж архивын лавлагааг 73 иргэнд тус тус гарган үйлчилсэн байна.

Тэтгэвэрт шинээр орсон 164 иргэн, тэжээгчээ алдсан, тахир дутуу, өндөр насны тэтгэмж тогтоолгосон 116 иргэнд 118,2 сая төгрөгийг олгосон

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилт сунгагдсантай холбогдуулан одоогоор 20 иргэний материал хүлээн авч хянаж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Гэр бүлийн зөрчил үйлдэж Аймгийн цагдаагийн газарт баривчлагдсан иргэдэд 4 удаагийн "Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт"-ыг зохион байгуулж, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 13 иргэнийг хамруулсан.

Баруун-Урт сумын 9 хамтарсан багтай кейс хурал хийж, кейс шийдвэрлэлтийн талаар арга зүйн зөвлөмж өгч сумын хамтарсан багт 40 гэр бүлийн хүчирхийллийн кейсийг харьяаллын дагуу шилжүүлэн ажиллаж байна.

13 сумын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд хамтарсан баг, гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл чиглэлүүдээр онлайн хурал зохион байгуулсан.

Хүүхдийн эрх хамгаалалтай холбоотойгоор Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4-р сургууль "Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо" онлайн чуулган "Хөгжсөн хүүхэд хамгаалагдана" сэдвээр, Баруун-Урт сумын 2-р сургууль, 10-р цэцэрлэгийн анги, бүлгийн багш нарт хүүхдийн эрх хамгааллын асуудалд анги болон бүлгийн багш нарын оролцоо сэдвээр сургалт уудыг зохион байгуулсан.

“Хайрын түүх” нэврүүлгийн хоёр дахь дугаарыг бэлтгэн байгууллагын пэйж хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Өсвөр насныхан эцэг эхчүүдийн хоорондын харилцаа” сэдвээр, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчилах зорилгоор “Мираки” клубтэй хамтран “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль” сэдэв 2 подкаст хийж, олон нийтэд цахимаар хүргэж байна.

Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 төрийн бус байгууллагуудын удирдлагуудтай “Зангаагүй уулзалт”-ыг зохион байгуулж, нийт 360 000 төгрөгийн зарцуулсан. Цаашид хамтран ажлалх талаар болон 2021 онд хийх онцлох ажлын төлөвлөгөө танилцуулж санал солилцсон, цэцэрлэгийн 17 багш, ажилчдад 3R- хүүхэд, гэр бүл, залуучуудын эрх, үүрэг, оролцоо сургалтын 1-р модул хичээл “Би хэн бэ” өөрийгөө танин мэдэх нь сэдвээр сургалтыг зохион байгуулсан.

ХХҮГ-аас захиалгат ажлын байрны мэдээллийг тогтмол авч, 5 залууг ажлын байранд зуучилсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Монголын олимпийн хороо, Спортын шинжлэх ухаан, Биеийн тамирын боловсролын холбоо, Монголын биеийн тамирын багш нарын холбоо, Монголын үндэсний олимпийн академиас зохион байгуулсан “Биеийн тамир, спорт-Олимпизм-Шинжлэх ухаан” сэдэвт сургалтад ахлах дасгалжуулагч, мэргэжилтнүүд хамрагдсан.

Спортын төв заал, Б заал, Усан спорт чийрэгжүүлэлтийн төвийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэн, 2 цаг тутам хариутгал халдваргүйжилт хийж, заалны чөлөөт тоглолт болон байгууллага хамт олны тоглолтууд явагдаж байна.

Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр

Хил хамгаалах туслах хүчний зөвлөгөөнийг зохион байгуулж Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийг шинэчилэн байгуулсан. Үндэсний аюулгүй байдлыг хангах 2021 оны нэгдсэн төлөвлөгөөг батлуулсан.

“Архигүй Сүхбаатарчуудын төлөө” дэд хөтөлбөр, “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх” урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрүүдийн биелэлтийг нэгтгэж тооцсон.

Цагдаагийн газар: Улаанбаатар хотод халдварын сэжигтэй тохиолдол илэрсэний дараа буюу 2020.12.01-ний өдрөөс эхлэн АОК-ын шийдвэрээр Хэнтий, Сүхбаатар аймгийн нутгийн зааг “Давсан бадрах” гэх газар /тус аймгийн бүх сумд руу чиглэсэн замын гол уулзвар цэг/-т байрлах үйлчилгээний төвийг түшиглэн хяналтын түр пост байгуулж, ЦГ-2, ОБГ-2, МХГ-2, нийт 6 алба хаагч үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Энэ пост нь Улаанбаатар хотоос ирсэн тээврийн хэрэгсэл болон иргэдийн зөвшөөрлийн бичиг, QR кодыг шалган, гэрийн ажиглалтад орох сумдын ажлын хэсэгт урьдчилан мэдэгдэх, зөвшөөрөлгүй ирсэн иргэд болон сэжигтэй тохиолдол илэрсэн үед Шуурхай штабт яаралттай мэдэгдэж, хариу арга хэмжээний бэлтгэлийг хангуулах, улмаар хавьтал үүсгэхээс сэргийлэн хөтөч автомашинаар аймгийн төвд хүргэх ажлыг зохион байгуулсан.

УОК-ийн 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэрээр Улаанбаатар хотод байгаа иргэдийг татан авах ажиллагааг 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл зохион байгуулах болсонтой холбогдуулан “Давсанбадрах” гэх газарт байрлах хяналтын постын хүчин чадлыг нэмэгдүүлж, цагдаагийн 2, онцгой байдлын 2, мэргэжлийн хяналтын 1, эрүүл мэндийн газрын 7, мал эмнэлгийн 1 зэрэг, нийт 13 алба хаагч, ажилтныг томилон үүрэг гүйцэтгүүлж, Улаанбаатараас ирж буй иргэн бүрээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, нэвтрүүлж байна.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хурлаас Алтан овоо, Шилийн богд, Дарханхан, Зотолхан уулын чиглэлд тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг энэ оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хориглосон тул

иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор тус аймгийн Баруун-Урт, Асгат, Сүхбаатар, Дарьганга, Мөнххаан, Онгон сумдын нутаг дэвсгэрт 8 түр пост шинээр байгуулж, цагдаагийн 7, бусад байгууллагын 14 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар спиртийн өндөр агууламж бүхий /18 градусаас дээш/ согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон хугацааг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүртэл 14 хоногоор сунгах шийдвэр гаргуулсан. Архи, согтууруулах ундаа /18 градусаас дээш/ зарахыг хориглох тухай аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 01-ний А/83 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Мэргэжлийн хяналтын газартай хамтран тусгай зөвшөөрөлтэй 58 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, архийг тоолж лацдав. Энэ төрлийн зөрчлийг илрүүлэх зорилгоор эргүүл, хяналт шалгалтыг чангатган “Шагчин” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж ажилласны үр дүнд цагийн хуваарь зөрчиж архи, согтууруулах ундаа худалдсан 10 дэлгүүр, гар дээрээс архи, согтууруулах ундаа худалдан борлуулсан 6 иргэн /таксины жолооч/, нийт 16 зөрчил илрүүлэн зөрчлийн хэрэг нээн, шалгаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/105 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх цагийг богиносгож, 08:00-17:00 цаг хүртэл ажиллах шийдвэр гаргуулсан.

Шүүхээс цагдаагийн байгууллагад эрэн сурвалжлахаар даалгасан этгээдүүдийг олж тогтоох ажлыг эрчимжүүлэх, үр дүнг ахиулах зорилгоор тус цагдаагийн газраас аймгийн хэмжээнд “Шүүхээс даалгасан хүн-2021” хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 14 хоногийн хугацаанд зохион байгуулж, эрэн сурвалжлагдаж байсан 14 хүний хаяг, байршлыг олж тогтоон, эрэн сурвалжлах ажиллагааг зогсоов.

Экологийн цагдаагийн албанаас ирүүлсэн удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах зорилгоор “Эко-2021” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна. Арга хэмжээний хүрээнд мөрдөгч нарт энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагааны үед анхаарах асуудлын талаар зааварчилга бичиж хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2021 оны төсөвт шинээр нэмэгдсэн олон нийтийн цагдаагийн сул орон тоонд 2020 оны 02 дугаар сарын 01-ээс 15-ны өдрүүдэд сонгон шалгаруулалт зохион байгуулав. Сонгон шалгаруулалтад тэнцсэн 13 иргэнийг 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдөр олон нийтийн цагдаагаар томилж, батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл: Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-244 анхны бүртгэл-29, өмчлөх эрх шилжих гэрээ-24, барьцааны гэрээ-144, бүртгэлд өөрчлөлт оруулах -1, лавлагаа хуулбар-7, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-53,

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-164, анхны бүртгэл-23, өмчлөх эрх шилжих гэрээ-25, барьцааны гэрээ-90, бүртгэлд өөрчлөлт оруулах -14, лавлагаа хуулбар-1 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-60, нийт бичигдсэн лавлагааны тоо-1

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: 2021 оны 02 дугаар сарын 28-ны байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо 1 Үүнээс ХК-5, ХХК-0, төрийн бус байгууллага-3, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -1, орон нутгийн өмчит

аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар-0, нөхөрлөл-0, хоршоо-0, хадгаламж зээлийн хоршоо-0, сан-0, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-1, шашны байгууллага-0, хэвлэл мэдээллийн байгууллага-0 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-0, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-1, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-0, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт - 0, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналт лавлагаа олгосон -0, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 0 –г тус тус бүртгэн хурааж авсан байна.

Иргэний бүртгэл: Иргэний бүртгэлийн тасаг нь 2021 оны 01 дугаар сарын байдлаар нийт 111 төрөлт, гэрлэлт 58, гэрлэлт цуцлалт 5, үрчлэлт 3, эцэг тогтоолт 13, овог нэр өөрчлөлт 1, нас баралт 34 , аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 43, үндэсний энгийн гадаад паспорт 17, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 58, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 8 тус тус бүртгэгдэж олгосон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр: Тус газрын хорихоос өөр төрлийн ялын хяналтад 2021 оны 02 дугаар сарын байдлаар торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 14 ялтны 53400000 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 22 ялтны 24630000 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 17 ялтны 12750000 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 19 ялтны 65208000 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эрх хасах ялын урьд оны 25 ялтны 11729 хоногийн үлдэгдэл дээр 7 ялтны 5840 хоногийн материал нэмэгдэж, 3 ялтны 2626 хоногийн хугацаа дуусаж, үлдэгдэл 29 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны үлдэгдэл 5 этгээдийн 19764000 төгрөг материал дээр шүүхээс шинээр 6 этгээдэд холбогдох 542000 төгрөгөөс 4 этгээдийн 5406000 төгрөгийн хөрөнгө орлогын хураасан авч орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр нийт 219 гүйцэтгэх баримт бичгийн 1957064,8 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулснаас 76 гүйцэтгэх баримт бичгийн 207184,0 мянган төгрөгийн төлбөрийг биелүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 25,1 хувьтай байна.

Тав. Батлан хамгаалах салбарт

Батлах хамгаалахын төв архив, Тагнуулын ерөнхий газрын тусгай архив, Хил хамгаалах ерөнхий газрын хилийн цэргийн төв архивуудад цэргийн алба хаасан тухай архивын лавлагааг хүссэн 9 иргэний хүсэлтийг албан бичгээр гаргуулан олгосон.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/39 дүгээр захирамжийн дагуу бэлтгэл офицер, цэргийн үүрэгтний бүртгэлийг 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл зохион байгуулсан.

ЗХЖШ-ын даргын захирамжийн дагуу Цэргийн штабын офицерууд “Стратегийн команд штаб”-ын сургуульд 2 дугаар сарын 23-26 ны өдрүүдэд ажиллалаа.

Зургаа. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд

Барилга, хот байгуулалт, газрын харилцаа: Аймгийн хэмжээнд хаягжуулалтын ажлыг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж 02 дугаар сарын 17- 24-ний өдрийг дуустал бүх сумдын газрын даамлуудыг 2 хэсэгт хуваан хаягийн мэдээллийн нэгдсэн систем дээр ажиллах сургалт зохион байгуулж, бүх сумдын хаягийн системийн засвар өөрчлөлт, шинэчлэлтийн ажлыг үр дүнтэй гүйцэтгэж ГЗБГЗЗГ-т ажлын тайланг хүргүүллээ.

Газрын кадастрын вэб системээр дамжуулан иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн 17 хүсэлтийг судалж шийдвэрлэн ажилласан байна. Мөн 14 иргэн хуулийн этгээдийн хүсэлтийн

дагуу аймгийн Засаг даргын захирамж гаргуулсан газрын кадастрын систем дээр Засаг даргын захирамж бүртгэн ажилласан байна. Аймгийн Засаг даргаар захирамж гаргуулахаар нийт 2 иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг албан бичгээр уламжлан хүргүүлээд байна.

Сумын ИТХ-аас баталж газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим системд баталгаажуулсан сумдын 2021 оны тухайн жилийн төлөвлөгөөг иргэд олон нийтэд нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулж байгууллагын цахим хуудас болон сумдын цахим группэд байршуулан ажиллалаа.

Энэ онд аймгийн хэмжээнд газрын төлбөр төлөгч 1375 иргэн аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээрийн газрын төлбөрийн нэхэмжэхийг татварын хэлтэст бүрэн илгээсэн. Нэхэмжлэх үүсгэхэд алдаа заасан 45 газрын төлбөр төлөгчийн судалгааг аймгийн Татварын хэлтэст засуулахаар хүргүүлсэн.

Энэ сарын 24-26-ны өдрүүдэд Баруун-Урт, Мөнххаан сумдад 7 байршлын газрын дуудлага худалдаа амжилттай зохион байгуулагдсан. Эдгээр дуудлага худалдааны ялагч гэрээний дагуу мөнгөө бүрэн төлсөн тохиолдолд аймгийн төсөвт 109668,8 мянган төгрөг, Мөнххаан сумын төсөвт 5265,6 төгрөгийн орлого тус тус төвлөрнө.

Сумдын засаг даргын тамгын газрын холбогдох албан хаагчдад, улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, санхүүжүүлэх, өмчийн бүртгэлд авах талаар сургалт зохион байгуулж, ОНХС-ын үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн, жилийн гүйцэтгэлийн үнэлгээний талаар заавар зөвлөмж өгсөний зэрэгцээ хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил цаашид анхаарах асуудлуудын талаар мэдээлэл хүргэж ажиллалаа.

Баруун-Урт сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажлын хэсгийн хуралдаанаар ажлын гүйцэтгэл, шинээр магадлалаар батлагдсан төсөв, ажлын бодит гүйцэтгэлийг тулган шалгах ажлыг ГХБХБГ-т даалгаснаар анхны ажлын төсөв болон сүүлд батлагдсан төсөв хоёрыг тулган шалгах ажил хийгдэж байна.

2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 6 төсөл арга хэмжээний ажлын зураг төсвийн даалгавар боловсруулан холбогдох газруудад хүргүүлээд байна.

Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн тайлан мэдээг Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 206, А/184 дугаартай хамтарсан тушаалаар баталсан маягт, зааврын дагуу 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн дотор n.enkhjargal.barilga.gov.mn enkhzulenkhtuya152@gmail.com цахим хаягаар EXCEL, PDF файлаар ирүүлэх албан бичгийг барилга угралт болон материал үйлдвэрлэгч 16 аж ахуй нэгжүүд рүү хүргүүлэн ажиллалаа. Жилийн эцсийн тайлан мэдээг нэгтгэн заавар зөвлөмж өгч тайланг хугацаанд барилгын хөгжлийн төвд хүргүүлээ.

2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих зайлшгүй шаардлагатай Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилга дээр газар дээр нь үзэж танилцан зургийн даалгаврыг боловсруулан холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа.

Зам тээвэр, уул уурхайн салбарт: 2021 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан аймгийн төвийн 2-р тойргийн хатуу хучилттай авто замын их засвар шинэчлэл, Цэргийн анги чиглэлд болон Шагайтай тойргоос хойшоо Өлзийтэй тойрог хүртэлх хатуу хучилттай авто замын засварын ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр шалгарсан “Классик роуд” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн.

2021 онд хэрэгжүүлэх авто зам, замын байгууламжийн ажлын зургийн даалгавар, техникийн тодорхойлолтуудыг боловсруулан батлуулж ажиллаж байна.

Засгийн газрын 2012 оны 222, 2017 оны 263 дугаар тогтоолоор байгуулагдсан ОУИТБС-ын засаглалыг сайжруулах ажлын албанаас зохион байгуулсан цахим сургалтад аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан дэд зөвлөлийн бүрэлдэхүүн оролцож 2020 онд ОУИТБС-ын аймгийн дэд зөвлөлөөс хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг тавьж 2021 онд ажлын албанаас хэрэгжүүлэх, зохион байгуулах ажлын төлөвлөгөөний саналтай танилцаж санал солилцож ажилласан.

“Эм Эл Цахиурт Овоо” ХХК-аас ирүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг “Дорноговь аймаг руу гүйцэтгэх, чиглэл батлуулахтай холбоотой хүсэлт, материалыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран танилцан хэлэлцэж, холбогдох зөвлөмж чиглэл гарган аж ахуй нэгжид өгч ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын даргын 2021 оны 05 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Эрдэнэцагаан сумын нутаг дахь Андын илч ХХК-ийн ашигт малтмалын ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа болон гаалийн хяналтын талбайн нөхцөл байдалтай танилцаж, дүгнэлт гарган ажиллалаа.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолой барих төслийн бүтээн байгуулалтын ажил эхлэхтэй холбогдуулан Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-аас ирүүлсэн албан бичгийн хүрээнд орон нутгийн холбогдох шаардлагатай мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Долоо. Бусад

Стандарт, хэмжил зүйн чиглэлээр: Баруун-Урт сумын 4 дэлгүүр, Халзан сумын 1 дэлгүүрийн тохирлын гэрчилгээ сунгуулах өргөдлийг хүлээн авч баталгаажуулалтын зөвлөлийн 2021.02.25-ны өдрийн №18 тоот хуралдаанаар шийдвэрлэж гэрчилгээг олголоо.

Иргэдээс ирэх хэмжүүр хэмжих хэрэгслийг баталгаажуулах хүсэлтийн дагуу 1 фазын цахилгаан тоолуур 3 ширхэгийг баталж, 2 иргэний гомдол хүсэлтийг барагдуулж ажилласан. Худалдаа үйлчилгээний газрын 4 ширхэг электрон жинг шалгалт баталгаажуулалтад хамруулан ажилласан. Мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн лабораторийн аналитик жин-3 ширхэгийг тус байгууллагын лабораторын орчин шалгалт тохируулганд хамруулсан.

Сүхбаатар аймгийн Нефть хангамжийн салбарын дуудлагаар Баруун-Урт сумын НИК ШТС-3 шатахуун түгээх станцын хурдны түгээгүүрийн хэвийн ажиллагаанд хяналт тавив.

Хэмжих хэрэгсэл шалгалт баталгаажуулалтын гэрээг Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа Шунхлай говь, СОД монгол грүүп ХК-тай, мөн ДБЭХС-төк-ын сүхбаатар салбар, АНЭ-тэй 2021 онд хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалсан.

Худалдаа үйлчилгээний газрын 13 ширхэг электрон жинг шалгалт баталгаажуулалтад Мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн лабораторийн аналитик жин-3 ширхэгийг тус байгууллагын лабораторийн орчин шалгалт тохируулганд тус тус хамрууллаа.

Салбар сангийн чиглэлээр: Стандартыг түгээх үндсэн үүргийнхээ хүрээнд Ковид-19 цар тахалтай холбоотой стандартуудыг аж ахуй нэгж, байгууллага, аймаг, сумдын онцгой комисс, иргэдэд хүргэх үүднээс холбогдох цахим хуудсуудаар дамжуулан түгээсэн. Мөн АНЭ, БОАЖГ, ХХААГ зэрэг төрийн байгууллагуудад 2020 онд батлагдсан стандартын жагсаалтыг нь өгсөн.

1 аж ахуй нэгжид MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага стандартаар, 1 гоо сайхны салонд MNS 5567:2006 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага стандартаар тус тус үйлчилсэн.

Аймгийн МСҮТ-н сургалтын менежер, дотуур байрны багш, дотоод чанарын баталгаажилт хариуцсан ахлах мэргэжилтэн, захиргаа аж ахуйн менежер, жижүүр үйлчлэгч гэх мэт хүмүүст MNS 6890:2020 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур

байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага стандартаар сургалт хийж, МСҮТ-тэй холбогдох стандартын жагсаалтыг өглөө.

Баруун-Урт сумын ЗДТГ, АНЭ болон хэлтсийн ахлах мэргэжилтэнд стандартын мэдээлэл лавлагаа өгч хэлтсийн Стандартын салбар сангийн журмын 02-р хавсралтын дагуу бүртгэлжүүлсэн.

Найм. Сумдад зохион байгуулагдсан ажил

Баруун-урт:

Цагаан сар-2021” байгууллагын ахмуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 20 ахмад настанг хамруулж хүндэтгэл үзүүлсэн.

Тайлант хугацаанд иргэдэд шаардлагатай багийн Засаг даргын 268 ш тодорхойлолт гаргаж үйлчилсэн. Мөн багийн ажлын алба 362 өрхөөр орж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажилласан.

Төрийн үйлчилгээний оператораас 9-н төрлийн 64 үйлчилгээ лавлагааг иргэдэд түргэн шуурхай гаргаж үйлчилсэн байна. Үүнийг ангиллавал:

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Засгийн газрын тогтоолын дагуу сумын аюулгүй нөөцийн 6500 боодол өвсийг малчин, мал бүхий өрхөд үнэгүй тараах ажил хийгдэж байна.

Нийгмийн хамгааллын чиглэлээр: Сумын ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Ээлжит бус IV хуралдаанаар сумын хамтарсан багийн бүрэлдэхүүнийг батлууллаа. Тайлант сард ГБХЗХГ-аас сумын хамтарсан багт 27 кейс ирж хариу арга хэмжээг авч 2 удаа хуралдан 10 кейсыг хааж хүргүүллээ. Багийн ажлын албаны “Хамтарсан баг”-т кейс өргөдөл хөтлөх зөвлөгөө өгч ажиллалаа.

Сүхбаатар аймгийн Хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хүүхдийн ядуурлын чиглэлээр нэн тулгамдаж буй асуудлыг гаргаж ирэх түүнийг шийдвэрлэх , тэдгээрийг даван туулах арга замыг тодорхойлох хэлэлцүүлгийг Японы Хүүхдийг ивээх сангийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран зохион байгууллаа.

Хууль эрх зүйн чиглэлээр: “Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийг сумын ИТХ-аар батлуулан, жилийн ажлын төлөвлөгөө гарган батлуулаад байна.

Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр: Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт удааширч байгаа тул зээлийн төлөлтийг сайжруулах талаар Аймгийн прокурорын газартай хамтран ажиллаж байна. Мөн хугацаа хэтэрсэн 25 зээлдэгч нарт мэдэгдэх хуудас хүргүүлээд байна.

Дэмжлэг, тусламж: Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал дотоодод дэгдсэнтэй холбогдуулан, 184 өрхөд 6228800 мян.төгрөгийн өртөг бүхий хүнс, түлээ нүүрс, бусад бараа материалын дэмжлэгийг үзүүлсэн.

Иргэд үйлчлэх төвийн төсвийн хөрөнгөөр Баруун-Урт сумын зорилтод бүлгийн 135 өрхөд 3358800 мянган төгрөгийн өртөг бүхий хүнсний дэмжлэг үзүүлсэн.

Өндөр хамар хоршооноос 1,5,8-р багтай хамтран зорилтот бүлгийн 45 өрхөд тус бүр 50000 мян.төг, нийт 2250.000 мянган төгрөгийн цагаан сарын багц хүнсний дэмжлэг үзүүлсэн.

5-р багийн аймгийн ИТХ-ын төлөөлөгч нараас багийн иргэн өндөр настанд 550000 мян.төгрөгийн өртөг бүхий массажны гудас, хүнс, нүүрсний дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна.

Баяндэлгэр:

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Аймгийн Засаг даргын 2010 оны 05-р сарын 17 ны өдрийн 201 дүгээр захирамжаар баталсан Аймгийн сайн малчны болзол журмыг хангасан 4 малчин өрх, Сумын аварга малчны болзол журмыг хангасан 10 малчин өрхийн материалыг Засаг Даргын Зөвлөлөөр хэлэлцэж материалыг Аймгийн ХХААГазарт хүргүүлж Аймгийн сайн малчин өрх 2, Сумын аварга малчин өрх 9 ийг тодруулж шагналыг гардуулж хүндэтгэл үзүүлсэн.

2021 оны 01 дүгээр сарын 07 –ны өдрийн А/13 тоот захирамжаар 2021 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажил явагдаж дүн мэдээг аймгийн цэргийн штабт 03 дугаар сарын 01-нд хүргүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.

2021 оны 02 дугаар сарын 17 –ны өдрийн А/25 тоот захирамжаар коронавируст халдвар / ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд архи согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 08:00-17:00 цаг байхаар тогтоон, хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг хариуцлагыг бүрэн биелүүлж, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллахыг согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн дарга эрхлэгч нарт үүрэг болгон хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах талаар цагдаагийн тасагт үүрэг өгч ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Ажил хайгч 32 иргэдийн мэдээллийг сэргээсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Сар шинийн баяраар байгууллагын харъяалалгүй 390 ахмадын нэрсийг сумын АДЗ-ийн хурлаар оруулж 390 ахмадын хүндэтгэлд 3900000 төгрөг олгосон.

Насны хишиг алдарт эхийн одонгийн мөнгө олгохтой холбогдуулан нэр данс зөрүүтэй иргэдийн мэдээллийг Хаан,Төрийн банктай тулгалт хийн зөрчлийг арилган 440 алдарт эхэд, 196 насны хишиг авах ахмадуудад мөнгийг олголоо.

Халамжийн тэтгэвэр цахимд шилжиж байгаатай холбоотой 74 иргэний дансыг Хаан,Төрийн банкнаас дансыг авч утасны дугаарыг e.halamj.mn цахим системд оруулаад байна.

Сургууль: 1-р ангийн 4 бүлгийн 96 сурагч, 2-р ангийн 3 бүлгийн 96 сурагчдад 2 цагийн математик, монгол хэлний хичээлээр нэг анги 3 ээлжээр буюу 10-с дээшгүй сурагч хамруулж давлага өгч байна. Мөн 5-р ангийн 3 бүлгийн 87 сурагчдад 2 цагийн давтлага, 9-р ангийн 2 бүлгийн 62 сурагчаас 54 сурагч давтлаганд хамрагдаж , мэргэжлийн 12 багш 6 хичээлээр 2 цагийн давтлага өгч байна.

12-р ангийн 72 сурагчийн 9 хичээлээр 10 мэргэжлийн багшийн ЭЕШ –д бэлтгэх чиглэлээр танхимын давтлага 1 сарын 27- оос эхэлсэн.

Соёл: Соёлын төвийн хамт олны сар шинийн баярт зориулан бэлтгэсэн “Энх мэндийн аялгуу” тоглолтыг Соёлын төвийн болон сумын бусад группүүдээр лайваар шууд дамжуулан үзэгчдэд хүргэлээ.

Хүүхдийн цэцэрлэг: Байгууллагын цахим хуудсанд болон бүлгийн дотоод групп чатуудаар хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар 14 зөвлөмж зөвлөгөөг байршуулан нийт 168 хүний хандалт авсан байна.

Бүлгийн багш нар теле хичээлийг тасралтгүй үзүүлэх тал дээр анхаарч эцэг эхчүүдтэй утсаар болон цахимаар холбогдож үзэж чадахгүй байгаа хүүхдийн шалтгааныг тодруулж нөхөж үзүүлэх болон гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн багцыг аялуулж үр дүнг тооцон ажиллаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Үйлдвэрлэл эрхлэгч 16 иргэний төслийг сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцэж 13 иргэний төслийг дэмжин шалгаруулсан.

Сумын Засаг Даргын 2021 оны 02 дугаар сарын 17- ны өдрийн А/25 тоот захирамжийн дагуу цагдаагийн тасагтай хамтран Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй 13 аж ахуй нэгжид хяналт тавин ажиллаж байна.

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийн мэдээг долоо хоног бүрийн 4 дэхь өдөр ХХААГазарт хүргүүлж байна. Сумын аюулгүй нөөцөд 400 боодол өвсийг нэмж татан авсан.

Мал эмнэлгийн чиглэлээр: 2020-2021 оны өвөл цас ихтэй, хүйтэн, цаг уурын орчны шинжилгээний байгууллагаас гаргасан дүгнэлтээр цагаан зудархуу байдалтай байгаа тул 1 наст төл мал болон тарга тэвээрэг муу авсан малууд, хуц ухна ширвэгдэн хорогдсон. Өнөөдрийн байдлаар сумын хэмжээнд адуу -22, үхэр -65, хонь-621, ямаа-662 бүгд 1370 хорогдсон мэдээтэй байна. Үүнээс хуц -42, ухна-64 хорогдсон. Мөн тэжээлд орсон мал их байгаагаас хордлогын шинжтэй дуудлага 4 удаа ирж түүнд явж үйлчилсэн.

Байгаль орчин: Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг явуулж нийт 300 өрхийг Орчны бохирдол аппликейшэнд шивж оруулсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй 5 ААНэгжүүдийн холбогдох бичиг баримтыг авч БОАЖГазарт хүргүүлээ.

Тус суманд үйл ажиллагаа буй 15-н ААН-тэй хог хаягдлын гэрээ байгуулсан. Аргаль хонинд биотехнологийн арга хэмжээ авч ажиллалаа.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр:

ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлыг 2021.02.18 ны өдөр хуралдаж дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1.Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах хэсгийн нутаг дэвсгэр төвийг тогтоох тухай. Зурагт болон ухуулах хуудас байршуулах, байршил тогтоох тухай • ИТХ-ын бүтэц, орон тоо батлах тухай • Дарьганга тохижилт үйлчилгээ /ОНӨААТҮГ/-ын бүтэц, орон тоо цалингийн санг шинэчлэн батлах тухай асуудлуудыг хэлэлцэн баталсан.

ИТХ-ын ажлын албанд Алдарт эхийн I , II зэргийн одон авах эхийн материалыг хүлээн авч байна.

Сумын Засаг даргын захирамжаар цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Тамгын газрын даргаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй, Агаар бохирдлын эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг 15 хүний, Үйлчилгээний газруудад хяналт шалгалт , хууль эрх зүйн сурталчилгаа зохион байгуулах ажлын хэсгийг Цагдаагийн хэсгийн төлөөлөгчөөр ахлуулан 5 хүний бүрэлдэхүүнтэй тус тус томилон ажиллалаа. Сар шинийн баярыг тохиолдуулан “ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлж хөдөлгөөний тэг зогсолтын арга хэмжээг авч, эргүүл постыг ажиллуулсан.

Цахим үйлчилгээний нэгдсэн төвийн операторч нь хоёрдугаар сард 7 төрлийн үйлчилгээг 13 иргэнд үзүүлсэн.

Сургалт сурталчилгааны чиглэлээр: Сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран “Цагаан сар нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулж, “Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар” гэсэн пэйж хуудсанд 84 төрийн албан хаагч нэгдлээ. Мөн албан байгууллагуудын гамшгийн үеийн бэлэн байдлыг 11 үзүүлэлтээр хянан шалгах арга хэмжээг зохион байгуулж, дүгнэлт хийсэн.

Сургууль, цэцэрлэгийн талаар: Холбогдох тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд 1, 2, 5, 9 дүгээр ангийн сурагчдын танхимын давтлагыг 02 дугаар сарын 18 ны өдрөөс албан ёсоор эхлүүлж 87 сурагч хамрагдахаас 66 сурагч хамрагдаж 76 % - тай байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: “Осол гэмтлээс сэргийлэх” хөтөлбөр төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хором бүрээ хяная” нэг сарын аяныг өрнүүлэн ажиллаж, аяны хүрээнд сурталчилгааг 88 иргэнд хүргээд байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын 4 багийн 373 хот айлын 224131 толгой мал хаваржина. Төллөх эх мал нь ингэ 38, гүү 7974, үнээ 8501, эм хонь 50508, эм ямаа 29329 нийт 96350 эх мал төллөнө.

Том малын зүй бус хорогдол адуу 31, үхэр 81, хонь 506, ямаа 537 нийт 1155 толгой малын хорогдолтой байна.

Бог малын хээлтүүлэгчийг ялган 5 суурь болгон суурилсан. 4, 1-р багт байгаа богийн хээлтүүлэгчийн суурь нь бэлчээрийн хомсдолоос болж богийн хээлтүүлэгчийн хорогдол нилээд гарч байна. Өнөөдрийн байдалаар цас хайлж мөстсөнөөс мал бэлчээрлэхэд нилээд хүндэрч байгаа нь хаваржилт хүндрэх төлөвтэй байна. Мөн 3,4 багийн өрхүүд бэлчээргүй болсоны улмаас хаваржаандаа бууж байна.

Өвсний фондод нөөцөлсөн 72 тн өвсийг малчдад тараан өгөх ажлыг зохион байгуулаад байна.

Байгаль хамгаалах чиглэлээр: Аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийх, хууль эрх зүйн сурталчилгаа хийх ажлын хэсгээс аж ахуйн нэгжүүдтэй хог хаягдлын гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй 47 ажил хайгч иргэний мэдээллийг сэргээсэн.

Нийгмийн халамжийн талаар: Нийгмийн халамжийн цахим системд бүртгэлтэй насны хишигт хамрагдах 129 иргэн, алдарт эхийн одонд хамрагдсан 236 иргэн, Wais системд бүртгэлтэй нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан

иргэний мэдээллийг тулгасан. Мөн И-халамж системд үйлчилгээ авагч 94 иргэний дансыг харилцагч банктай тулгаж, 5 иргэний овог нэрийн зөрчлийг арилгуулсан.

Албан байгууллагын харъяалалгүй 239 ахмадын нэрсийг Wais программд бүртгэсэн.

Жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр: Коронавируст халдвар-ны цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор спиртийн өндөр агууламж /18 градуссаас дээш/ бүхий согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосон хугацааг 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийг дуустал сунгасантай холбоотойгоор хэсгийн төлөөлөгчөөр ахлуулсан ажлын хэсэг аж ахуйн нэгжүүдээр явж согтууруулах ундааг худалдахыг хориглож лацдаж тусгаарласан.

Мөнххаан:

Сумын Засаг даргын А/28 дугаар захирамжаар цэргийн шинэчилсэн бүртгэлийг 2021 оны 01-р сарын 25 наас 2-р сарын 25 ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Цэргийн шинэчилсэн бүртгэлийг бүртгэлийн 14 маягтын дагуу нэгтгэлийг гаргаж , цаг хугацаанд нь тушаасан.

Тус сум нь 2020 оны ажил, үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүнгээр аймгийн хэмжээнд Дэд байр эзэлсэн амжилтыг үзүүллээ.

Төрийн үйлчилгээний чиглэлээр: Цахим үйлчилгээг үзүүлэх ажлын хүрээнд нийт 7 иргэнд лавлагаа гаргаж өгөөд байна. Нотариатын үйлчилгээг нийт 159 хүнд үзүүлээд байна.

Улсын бүртгэлийн чиглэлээр: Төрсний 12, гэрлэсний6, нас барсны 3, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 8, иргэний үнэмлэхний олголтын бүртгэл 17, хүчингүй болгосны бүртгэл 4-ийг тус тус бүртгэсэн. Шилжилт хөдөлгөөний бүртгэл 16-аас дээш насны 5, доош насны 3 иргэний бүртгэлийг тус тус хөтөлсөн. 10 иргэний эд хөрөнгийн бүртгэлийн анхны бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримтыг хүлээн авч аймгийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.

Төсөв санхүүгийн хүрээнд: 4-р багийн зорилтот бүлгийн 1 өрхийн гэр шатсан тул ЗД-ын нөөцөөс 500,0 мян төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.

Сургууль: 2021 оны 2-р сард амьдарч байсан гэр нь галд өртсөн нэг өрхөд сургуулийн багш ажилчдын зүгээс хандив цуглуулж нийт 500 мянган төгрөгний хандив, эд материалаар тусалсан.

12 дугаар ангийн сурагчдын танхимын давтлага эхэлсэнтэй холбоотойгоор сургуулийн орчин болон дотуур байранд бүрэн халдваргүйжүүлэлт хийж өдөр бүр 2 багш халдвар хамгааллын дэглэмийг сахиулан жижүүрлэн ажиллаж байна.

Хүчирхийлэлд өртөж байж болзошгүй 1 гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж гэрээр 2 удаа очиж эрсдлийн үнэлгээ хийсэн.

Теле хичээл үзэж чадахгүй байгаа болон гүйцэтгэл дутуу сурагчдад зориулан “Агуулга нөхөн эзэмшихэд зориулсан гарын авлага, зөвлөмж”-ийг 20 хичээлийн агуулгаар 22 багш 900 ширхэгийг хийж сурагчдад хүргэсэн.

“Өсвөр үеийхэнд хувь хүний чадвар, интерпернер боловсрол олгох сургалт”-д тус сургуулийн 6 багшийг хамруулсан. Ерөнхий Боловсролын сургуулийн хичээл сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг шинэчлэх, сурагчдад сурч хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд Фючерскүүл Монголиа ХХК-тай гэрээ байгуулан тус бүр нь 1.200.000 төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг самбарыг 14.400.000 төгрөгөөр худалдан авсан бөгөөд хичээлийн 1-р байранд 12 ангид тус самбаруудыг байрлуулж хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. 3 дугаар сарын 1-ний өдрөөс танхимын сургалт эхлэх

болсонтой холбогдуулан хичээлийн 1, 2-р байрууд болон дотуур байрыг бүрэн халдваргүйжүүлж сургалтын үйл ажиллагаа эхлэх бэлтгэл ажлыг бүрэн хангасан бөгөөд дотуур байрын сурагчдыг нэг бүрчлэн үзлэг шинжилгээнд хамруулсан.

Хүүхдийн цэцэрлэг: Тус сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2020 оны Ажил үйлсээрээ аймгийн хэмжээнд манлайлан 91.43 оноотой "А" үнэлгээтэйгээр [ТЭРГҮҮН](#) байр эзэллээ.

Теле хичээлийн үзэлт 2 сарын эхний 7 хоногт 64,0% тай 160 хүүхэд үзсэн. Үзэж чадаагүй хүүхдүүдэд бүлгийн багш нар теле хичээлийн агуулгыг бататгах нэмэлт дасгал даалгаварыг боловсруулж, туслах багш нарын хамтаар хүргэлтэд гарсан. Мөн хувилбарт сургалтын багцыг ердийн болон алслагдсан хөдөө байгаа хүүдүүдэд хүргэх ажлыг шат дараатайгаар зохион байгуулж, 517 ш хэвлэмэл материал бэлтгэж, 163 хүүхдүүдэд хүргэж эхлээд байна. Мөн бүлгийн группээр эцэг эхчүүд, болон хүүхэдрүү чиглэсэн нийт 39 зөвлөгөө зөвлөмж өгч 293 хандалт аваад байна.

Тогтвортой хөгжлийн боловсролыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор, хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах дахин боловсруулах, мэдлэг боловсролыг багаас нь олгох ажлын хүрээнд, хог хаягдал ангилж ялгах ажлыг бүх бүлгүүдэд нэвтрүүлж эхлүүлсэн бөгөөд туслах багш, ажилчид хогийн савыг шинэчлэн байрлуулж, хувиасаа нийт 803.000 төгрөг зарцуулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр: 2021 оны 02 сарын 28 -ны байдлаар 22 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 19 насанд хүрэгчид, 3 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

Амбулаторийн үзлэг 615 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 235 байна.

Түргэн тусламжийн дуудлага 135 ирснээс алсын дуудлага - 6, ойрын дуудлага 129 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Соёл урлагийн чиглэлээр: Соёлын төв нь 2020 оны ажил үйлсээрээ манлайлан аймгийн хэмжээнд ДЭД байр эзэллээ.

Цахимаар цар тахалтай холбоотой мэдээ мэдээлэл 20, соёл урлагийн мэдээ мэдээллийг 15 удаагийн давтамжтайгаар хүргэн 621 иргэдийн хандалт авч ажилласан.

Цагаан сарын баярт зориулан цахим уралдаан 2 удаа зохион байгуулан уралдаанд 15 авьяастнууд оролцлоо.

Байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор компьютерийн, соёл ба хөгжил, үйлчилгээний соёл, архивын хамтарсан сургалтуудыг зохион байгуулан ажиллаж сургалтанд байгууллагын 8 ажилтан хамрагдлаа.

Номын сангийн явуулын үйлчилгээг 25 иргэнд хүргэн 98 номоор үйлчилсэн.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: Шинээр энэ сард 2 ажлын байр бий болсон. Нийгмийн халамжийн тэтгэвэр цахимд шилжиж байгаатай холбоотой нийт 64 иргэний тэтгэврийн хувийн хэргийг тулган баталгаажуулж 60 иргэн баталгаажсан төлөвтэй байгаагаас 6 ахмадын тэтгэвэр, 54 хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр байна. 47 иргэний дансыг шинээр шивж, 13 иргэн данстай байна. Мөн 8 иргэн огт утасны дугааргүй 52 иргэний утасны дугаарыг шивж орууллаа.

Цагаан сарын шинийн нэгэнд харьяалалгүй ахмад настанд хүндэтгэл үзүүлж гарын бэлгэнд 326 ахмад настанд 3260,0 мянган төгрөгийг олгож 267 ахмадын утсанд сар шинийн мэндчилгээ илгээв.

ХЭБҮ-нд энэ 2-рсард шинээр 3 өрх нэмэгдэж 69 өрхийн 3520,0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. Мөн ХЭБҮ авагч Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгааг гарган явуулсан.

Хөдөө аж ахуй: Нөөцийн өвсийг 37 өрхөд тараасан нийт 925000 мянган төгрөг төрийн сангийн дансанд төвлөрөөд байна. 2 сарын зүй бусын хорогдлын мэдээгээр 2488 мал хорогдсон байна.

Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр: Сар шинэ болохтой холбогдуулан Нэгдсэн хогийн цэгийн тэлсэн хог хаягдлыг ковшоор түрж цэгцэлсэн.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн иргэдийн хурлын 2021 оны 01 сарын 14-ны өдрийн ээлжит бус 4-р хуралдаанаар Газар нутгийг тусгай хамгаалалалт, тусгай хэрэгцээнд авах тухай асуудал мөн аялал жуулчлалын түр буудаллах цэгийг улсын тусгай хамгаалалтанд авах тухай хоёр асуудлыг оруулж 100% саналаар батлуулсан. Аялал жуулчлалын “Түх буудаллах цэг”-ийг улсын тусгай хамгаалалтад авах тухай тогтоолыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн орон нутгийн тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авах газар нутгуудын талаарх санал шийдвэрийг Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын хэлтэст хүргүүлээд байна.

Газар зохион байгуулалтын чиглэлээр: Газрын кадастрын системд 2 иргэний Төмс, хүнсний ногооны усалгаагүй тариалангийн зориулалтаар газар эзэмших өргөдлийг цахимаар хүлээн авч, засаг даргын захирамжаар газар олголт хийн, иргэний гэрчилгээг олгож ажиллаа.

Сумын Засаг даргын А/20 тоот захирамжаар 4 байршилд зарлагдсан дуудлага худалдаа хугацаандаа амжилттай зохион байгуулагдаж дууссан.

46 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт хийж, 92 нэхэмжлэх үүсгэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 28 иргэн буюу 56 нэхэмжлэх төлбөрийн төлөлтийг хийгээд байна.

Хаягийн нэгдсэн цахим системд 99 гудамж, 610 байр зүйн нэгж талбар, 344 байр зүйн барилга, Кадастрийн мэдээллийн сангийн нэгж талбар 96.6 хувьтай, кадастрийн мэдээллийн сангийн барилгыг 95.4 хувийн гүйцэтгэлтэй орууллаа.

Наран:

Аймгийн Хөдөө аж ахуйн газраас 835 боодол өвс худалдан авч малчдад борлуулсан.

Боловсролын чиглэлээр: Сургуулийн өмнөх боловсролийн чиглэлээр эрүүл мэндийн зөвлөмж 3, сургалтын чиглэлээр бэлтгэсэн даалгавар 3, хүүхдийн хүмүүжил төлөвшилд зориулсан зөвлөмж-2 тус тус хүргэсэн. Нийт 113 хүүхдийн 68 эцэг эхтэй холбоотой ажиллаж байна.

Бүлгийн 113 хүүхдийн эрсдлийг тогтоож, нөхцөл байдлын судалгаа гаргасан.

“Уран уншигч” шүлгийн тэмцээнийг зохион явуулахад нийт 35 хүүхэд оролцлоо.

ЕБС нь 2020 оны жилийн ажлын чанарын болон тоон үнэлгээгээр 86.6%-тай үнэлэгдэж 2-р байр, эзэлж амжилт гаргасан.

2021.02.18-ны өдрөөс эхлэн 1,2,5,9-р ангиуд өглөө 08:00-11:00 цагийн хооронд халдвар хамгааллын дэглэм баримтлан давтлагыг зохион байгуулан ажиллаж байна.

Онгон:

Сумын аймгийн ХХААГазраас 920 боодол өвс ирсэнийг 8500 төгрөгөөр цаг хүндэрсэн бүс нутгийн малчдад тус бүр 10 боодол өвс өгөхөөр хуваарилан тарааж байна.

2020 онд аймгийн аварга малчин 4, сумын сайн малчин 11, мянгат малчин 16, улсын аварга малчин 1 тус тус шалгарлаа.

Сүхбаатар:

Их жанжин Д. Сүхбаатарын мэндэлсний 128 жилийн ойг тохиолдуулан жанжны хөшөөнд хүндэтгэл үзүүлж, Түүний үйл хэргийг сурталчлах, ирээдүй хойчид түүх соёлоороо бахархах хандлагыг төлөвшүүлэх зорилгоор Д. Сүхбаатарын тухай дууг хэн сайн дуулах вэ" цахим уралдаан зарлаж дүгнэлээ.

Байгаль орчин , Хөдөө аж ахуй: Хөдөө Аж ахуйн салбарт он удаан жил амжилт бүтээл гаргаж 2018-2020 он буюу сүүлийн гурван жилийн ажлын үзүүлэлтээрээ бусдыгаа манлайлсан Аймгийн сайн малчин 3, Сумын сайн малчин 14 болон мянгат малчид 13, тус тус тодорсон.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр: Аймгийн ЗД-ын А/106 захирамжийн дагуу 1 анги-49, 2 анги-35, 5 анги-23, 9 анги-24, нийт-131 сурагчдад ариутгал халдваргүйжилтийн дэглэмийг баримтлан давтлага зохион байгуулж байна.

- Цахим хичээл бэлтгэсэн тоо-46
- Цахим хичээлийн ирц-72.9%
- 5 дахь жилийн сургалтад хамрагдсан багш нарын тоо-3
- Онлайн сургалт-2
- Ажлын байран дээрх сургалтууд-4

Соёл урлагийн чиглэлээр: Цөөвөр хэмээгч цагаагчин үхэр жилийн босгон дээр соёлын төвөөс АМАР БАЙНА УУ сар шинийн баярын хөтөлбөрийг бэлтгэн хүргэв. Нэвтрүүлэгт сумын ахмадууд болон соёлын өвийн өвлөн уламжлагч нар оролцов.

Сүхбаатар сумын Соёлын төв нь тоон болон чанарын үнэлгээний нэгдсэн дүнгээр А үнэлгээ авч аймагтаа "Тэргүүн" байр эзлэв.

Түвшинширээ:

Хүүхдэд тавих хараа хяналтыг чангатгах, бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь үлдээхгүй байх, ахуйн хүрээнд архи дан согтуурахгүй байх, гэр бүл, үр хүүхдээ эрсдэлд оруулахгүй байх талаарх зөвлөгөө зөвлөмжийг ЕБС, СӨБ-ын багш нартай хамтарч фейсбүүкээр видео контент бэлтгэн тархааж байна.

Сумын Онцгой комиссын нөөцөд 4,4 сая төгрөгийн үнэ бүхий ариутгал халдваргүйтгэлийн бодис, хамгаалалтын хувцас, макс, био суултуур, гадна талбайн ариутгал хийх зориулалт бүхий мананцаржуулагч, зайнаас халуун хэмжигч зэрэг нэн тэргүүн шаардлагатай хэрэгслийг худалдан аваад байна.

УБ хотоос татан авалт болон хувийн унаагаар нийт 48 хүн ирснийг гэрийн ажиглалтад авсан. Эдгээр иргэдийг сумын Онцгой комиссын гишүүд хариуцан хяналт тавьж, мөн утсаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн БОАЖГазраас нэн ховор ан амьтан аргаль хонинд БИО техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Түвшинширээ сумаас 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр "Монгол улсын хошой аварга малчин"-1, Аймгийн сайн малчин-2, Сумын сайн малчин-6, Мянгат малчин-6 болзол хангасан байна.

Нийгмийн халамж: Ахмад настаны тухай хуулийн дагуу жилд 2 удаа олгох насны хишгийн мөнгөн тэтгэмжид нийт 119 ахмадад 9720,000 төгрөгийн мөнгөн тэтгэмжид хамрагдсан.

Боловсрол, Соёл: Коронавирус халдварт цар тахлын үед хорио цээрийн дэглэмийг чанд сахиж 8 бүлгийн багш нар теле хичээлийн үзэлтийн тандалт судалгааг тогтмол хийж байна. Үүнд теле хичээл үзсэн 196, үзэж чадаагүй 36 хүүхэд хамрагдалт 84,1%-тай байлаа.

Соёл урлагийн арга хэмжээний хүрээнд номын сангаас Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Нацагдоржийн шагналт Санжийн Пүрэвийн “Уулын намар” зохиолыг цахимаар унших боломжийг олгож ажиллалаа.

Хүүхдийн цэцэрлэг тусгаарлах байрыг 2 өрөөнд тохижуулж, ариутгалын материалын нөөц болон бусад зардалд 720,000 мянган төгрөг зарцуулсан.

Эрүүл мэнд: Эрүүл мэндийн сайдын 375 тоот тушаалын дагуу давхардсан тоогоор 41 удаа аж ахуй нэгж байгууллагуудад тандалтыг хийж хэвшээд байна. Коронавирусын вакцин хийгдэхтэй холбоотой хөтөлбөр төлөвлөгөө, байр сав ажиллах баг, хүчний тайлан мэдээг эрүүл мэндийн газарт илгээгээд байна.

Түмэнцогт:

Сар шинийн баярыг угтан аймгийн сайн малчин 1, сумын сайн малчин 2, энх сүрэгтэн 2, төл таван эрдэнэ 2, шилдэг уяач 1, шилдэг унаач 1, шилдэг харваач 1, мянгат малчин 2 шалгарч шагнал гардуулах, хүндэтгэл үзүүлэх ажиллагааг зохион байгуулж Засаг даргын нөөц сангаас 2.1 сая төгрөгийг зарцуулсан.

Аймгийн Засаг даргын албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд байнгын асаргааны ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүнс, тэжээлийн дэмжлэг 2,5 сая төгрөг зарцууллаа.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын хувцас, хэрэглэл, тусгаарлан ажиглах байр тохижуулах үйл ажиллагаанд 3,7 сая төгрөг зарцуулж бэлтгэл бэлэн байдлыг хангасан.

Нэгдсэн хогийн цэгийг “Ус-Дулаан” ААТҮГазар хариуцан 1,3 сая төгрөгийн шатахуун зарцуулан түрж цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хууль эрх зүйн чиглэлээр: Ковид-19 цар цахалтай холбоотой Улсын Онцгой комиссын албан даалгавар, ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч цахимаар 56 төрлийн мэдээллийг сумын 3 группээр дамжуулан иргэдэд хүргэсэн.

Шинэчлэгдэн найруулагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд цахимаар 6 төрлийн мэдээлэл 20 гаруй удугийн давтамжтай хүргэсэн.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөл байгуулж худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААНэгжүүдэд хяналт тавьж, заавар зөвлөмж, сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хөдөө аж ахуй: Сумын хэмжээнд өвөлжилт хүндэрч 2 багийн 92 өрхийн 61249 мян.толгой мал өвс тэжээлийн хомсдолд орж 150 тн өвс, 30 тн хивэг тэжээл шаардлагатай байгааг Аймгийн ХХААГазарт хүсэлтээр хүргүүлснээс Улсын нөөцийн нэгжээс малчин мал бүхий өрхөд хивэг тэжээл олгоа ажлыг эхлүүлээд байна.

Сумын хэмжээнд том малын зүй бусын хорогдол тэмээ – 1, адуу – 140, үхэр - 210, хонь -707, ямаа – 761, нийт – 1819 толгой мал хорогдож сумын нийт малын 1,3%-ийн хорогдолтой байна.

Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр: Ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлт гаргасан 2 иргэний бүртгэлийг мэдээллийн санд бүртгэсэн.

Сумын иргэдэд Хөдөлмөр эрхлэлт болон Халамжийн чиглэлээр хэрэгжиж байгаа үйл ажиллагааг суртачилах, мэдээ мэдээлэл өгөх зорилгоор “Хөдөлмөр, халамж Түмэнцогт сум” нэртэй цахим хаяг нээж иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж ажиллаж байна.

Албан байгууллагын харъяалалгүй 224 ахмад настны дансны болон утасны дугаарыг харилцагч банкуудаас авч waic мэдээллийн санд бүртгэж олгосон.

Ерөнхий боловсролын сургууль: БСУГазрын ажлын өгсөн үүргийн дагуу 02 сарн 18 өдрөөс 12-р ангид 7 хичээлээр, 1,2,5-р ангид Математик, Монгол хэлний хичээлээр, 9-р ангид Монгол хэл, Математик, Англи хэлний хичээлээр давлага өгч 178 сурагч, 18 багш хамрагдсан байна.

ЭМТөв: Энэ сард голомт бүхий бүс нутгаар зорчсон 84 иргэнийг гэрийн ажиглалтанд авч тогтмол хянаж түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулж ажиллав.

Давсан бадрах постод 1 бага эмч дайчлагдан ажиллаж нэвтэрсэн бүх иргэдээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч мэдээллийг ЭМТ-д ирүүлэн гэрийн ажиглалтанд авч ажилласан. Ковид-19 халдварын бэлэн байдлыг ханган нөөц бүрдүүлэлтэд 8,5 сая төгрөг зарцуулсан.

Уулбаян:

Төсөв санхүүгийн чиглэлээр: 1 сарын байдлаар орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 4849.0 мянган төгрөг орохоос 6503.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 134.1 хувийн биелэлттэй байна.

2-р сарын байдлаар аймгийн санхүүгийн дэмжлэг 58785,0 мянган төгрөг ирээд байна.

Худалдан авах ажиллагааны талаар:Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтанд 6 төрийн албан хаагчийг хамруулсан.

2021 онд орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл

| № | Хийгдэх ажил | Төлөвлөгөө | 2021 оны гүйцэтгэл | Үлдэгдэл |
|---|-------------------------------------|---------------|--------------------|---------------|
| 1 | Гэр цэцэрлэг нэмэгдүүлэх | 20,000,000.00 | | 20,000,000.00 |
| 2 | ЕБС-ийн мэдээлэл зүйн кабинет дутуу | 8,978,000.00 | | 8,978,000.00 |
| 3 | Нийтийн халуун усны барилга | 90,000,000.00 | | 90,000,000.00 |

| | | | | |
|---|---------------------------|-----------------------|----------|-----------------------|
| 4 | Чийрэгжүүлэлтийн төв | 35,000,000.00 | | 35,000,000.00 |
| 5 | Ухаалаг худгийн төхөөрөмж | 9,100,000.00 | | 9,100,000.00 |
| 6 | Цамхаг гэрэл | 9,200,000.00 | | 9,200,000.00 |
| 7 | Газар чөлөөлөлт | 46,165,700.00 | | 46,165,700.00 |
| 8 | Зураг төсвийн үнэ | 3,000,000.00 | | 3,000,000.00 |
| | Дүн | 221,443,700.00 | - | 221,443,700.00 |

Байгаль орчин: Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг сумын Засаг даргын 2021 оны А/20 тоот захирамжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн. Тооллогоор сумын хэмжээний айл өрх, албан газар, аж ахуй нэгжүүд хамрагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 03-ны өдрийн 211 тоот тогтоолын дагуу ус, дулааны үнийг төлбөрөөс чөлөөлсөнтэй холбогдуулан худаг, уст цэгийн тооцоо судалгааг гарган усны төлбөрийг буцаан олгох ажлыг хийж байна. 2020 оны 12 сарын усны төлбөр болох 1339000 төгрөгийг сумын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэнийг 4 газарт буцаан олгосон. 2 худгийг тооллуурт шилжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны санхүүжилтаар байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2021 оны төлөвлөгөөнд 3-4 булаг шанд хашиж хамгаалахаар тусгагдсантай холбогдуулан Уулбаян сум 2 булгийн эхийг хашиж хамгаалуулах саналыг хүргүүлсэн.

Газар зохион байгуулалт: 333 нэгж талбар, 71 гудамж, 308 орц, 1046 барилгын хаягийг хянаж, газрын мэдээллийн санд оруулсан.

Хөдөө аж ахуй: 2020 оны байдлаар Уулбаян суманд 903 өрхийн 2978 хүн амьдарч байна. Үүнээс малчин өрх 603 мал бүхий өрх 96 байна. 2020 онд 241807 мал тоологдсон байна. Малын тоо толгойг 5-н төрлөөр авч үзвэл тэмээ-767, адуу 17950, үхэр-14079, хонь- 131285, үхэр- 77726 тоологдсон байна. 2019 оны тоотой харьцуулхад тэмээ-94, хонь- 5126-аар буурсан бол адуу-686, үхэр-571, ямаа-300 – аар өссөн байна. ИТХурлаар малын хөлийн татварын хувьд адуу- 1000 төг, үхэр-400 төг, хонь-300 төг , ямаа-600 төгрөгийн татвар авхаар тогтоосон. 1 өрхөөс 150 толгой мал чөлөөлөхөөр адуу-10ш , үхэр-10ш , хонь-100ш , ямаа-30ш гэж тогтоогдсон. Уулбаян суманд 2021 оны 1 сарын байдлаар Том малын зүй бус хорогдол гараагүй байна.

Уулбаян суманд 6 нэр төрлийн ахуй үйлчилгээ эрхлэгч байна. Ахуй үйлчилгээ эрхлэгчдээс мэдээллийн хавсралт өгөгдлийн дагуу судалгааг авсан.

Нэр төрлөөр нь ангилан үзвэл:

- Авто машин засвар үйлчилгээ эрхлэгч- 4
- Гутал засвар үйлчилгээ эрхлэгч – 1
- Гэрэл зурагчин фото үйлчилгээ эрхлэгч- 1

- Хувцас захиалга үйлчилгээ эрхлэгч- 2
- Гэр ахуйн модон эдлэл захиалга эрхлэгч-1
- Үсчин-1

Ахуй үйлчилгээ эрхлэгчид нь 2008 - 2020 оны хооронд үйл ажиллагаа явуулж эрхэлсэн ба нас хүйсээр нь ангилан үзвэл эрэгтэй-6, эмэгтэй-4 байна. Үйл ажиллагаа явуулдаг өөрийн өмчлөлийн байртай 6 эрхлэгч байна.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 35258.8 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ. Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд - 26941.5 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 5398.5 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 2918.8 мян төг орлоо.

Эрүүл мэнд: Урьдчилан сэргийлэх үзлэг-144, амбулаторийн үзлэг –170, гэрийн дудлага-18, алсын дуудлага-16, артерийн даралт – 71, чихрийн шижингийн үзлэг-71, хөхний үзлэгт-52, 0-2 насны урьдчилан сэргийлэх тарилгад- 27, саагийн нэмэлт дархлаажуулалтанд-125 нийт 319 иргэд тус тус хамрагдсан байна.

Ерөнхий боловсролын сургууль: 1,2,5,9-р ангийн нийт 135 суралцагчдад давтлагыг бага ангийн 6 багш, мэргэжлийн 7 багш нар өгч байна.

“Хүүхэд хамгаалал”, “Ахуйн осол”, “Ковид 19” сэдвээр багш нар нийт 20 шторк бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулав.

Аймгийн нийтийн сангаас зохион байгуулсан “Амар мэндийн баяр” гар зургийн уралдаанд 6 хүүхэд оролцсоноос 3б ангийн сурагч О.Сарнай 2-р байр эзэлсэн. “Монгол банхараа хэн сайн зурах вэ?” уралдаанд 5 хүүхэд оролцсон.

Хүүхдийн цэцэрлэг: Багш нар гэрээр бүх бүлгийн “Теле хичээл”-ийг үзэж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Мөн теле хичээлийн хамрагдалт 80,7%-тай байна.

Соёлын төв: Нийтийн номын сан цахим хуудсанд тууж-2, өгүүллэг-31, танин мэдэхүйн нийтлэл-9 түгээж нийт 1520 хүний хандалт авсан байна. Сар шинийн баярыг тохиолдуулан Монгол ардын дууны уралдааныг иргэдийн дунд зохион байгууллаа.

Хууль, эрх зүйн чиглэлээр: 2020 оны 2 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг-1, Хүнийг алах – 1 гэмт хэрэг нийт 2, танхайрах зөрчил - 2 тус тус үйлдэгдсэн байна.

Халзан:

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах, мэдээ мэдээллээ ил тод шуурхай солилцох ажлыг зохион байгуулж, сар бүрийн ажлын эхний өдөр “УДИРДАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙН ЦАГ”-аар сумын нийт албан байгууллагуудын дарга эрхлэгч нартай уулзан мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

2020 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн ИТХ-ын тэргүүлэгчдийн ээлжит хуралдаанаар ЗДТГ-тай хамтын үйл ажиллагааг сайжруулах, ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй ил тод хүргэх зарчмын хүрээнд ЗДТГ-ын мэргэжилтэн, албан хаагч нарын 2020 оны ажлын тайлан, цаашдын зорилтын талаар тэргүүлэгчдийн хуралдаанаар нээлттэй сонслоо.

Малын тоо толгойн албан татварын хэм хэмжээг тогтоох эрх зүйн актыг Хууль зүйн яаманд хянуулж 2021 оны 01-29-ний өдрөөс эхлэн энэхүү журмыг дагаж мөрдөхөөр боллоо.

Энэ сард татварын орлогоор 3471,7 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 27544,2 мянган төгрөг авч нийт орлого 31015,9 мянган төгрөг төвлөрсөн байна. Мал хамгаалах санд өвсний үнэ 5264,0 мянган төгрөг төвлөрсөн.

ЕБС: Хүүхдийг болзошгүй осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр НТБН-ийн багштай хамтран “Хүүхэд хамгааллыг чиглэлээр” цахим хичээл бэлтгэн сум сургуулийн хаяг болон ангийн группүүдэд байршуулсан. Үүний үр дүнд эцэг эхчүүд болон сурагчдын эрх зүйн мэдлэг дээшилсэн. Эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдлэгтэй болсон. Сурагчдыг ахуйн осол гэмтэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шторк, боршур бэлтгэн сурагчдад тараасан.

Баруун- Урт сумын 3-р сургуулийн захиргаатай хамтран “Азийн сан, Канадын засгийн газрын санхүүжилтээр” эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 5 сурагчдад ахуйн хэрэглээний зүйлс, эд материалын дэмжлэг үзүүлсэн. Нэг сурагчдад – 50000х5

Цэцэрлэг: Бүлгийн багш нар үзүүлэн тараах материалдаа ашиглан 3, 3 ш эсгий олбог, Ёс заншилын өргөөнд 3 жижүүр газрын зурагтай самбар эсгий хавтангаар, Бүлгийн багш нар эсгийгээр ханын самбар хийж бүлгээ тус тус тохижууллаа. Туслах багш, тогооч, нярав нар өөрсдийн булантай болсон. \Эсгий\ Мөн 4 бүлэгт 1080000 төгрөгний хөшиг авч тохижилт хийлээ.

Байгаль орчны чиглэлээр: Сар шинийн баяр болсонтой холбогдуулан 50 өрхийн 30 тонн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлж ажиллалаа. Албан байгууллага, аж ахуй нэгж орчны цэвэрлэгээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд 5 албан байгууллагын 87 албан хаагч хамрагдав.

Эрдэнэцагаан:

Сумын ИТХ-ын 2021 оны 1 дүгээр сарын 29 өдрийн Ээлжит бус 5 дугаар хуралдаанаар: Адуу- 1300, Үхэр- 600, Тэмээ – 0, Хонь- 500, Ямаа- 1000-аар тус тус тогтоолоо. Сумын өрх тус бүрээс 100 толгой малыг татвараас чөлөөлж, сумын төсөвт 270 гаруй сая төгрөг төвлөрүүлэхээр тооцоолон ажиллаж байна.

Уламжлалт сар шинийн баярыг угтан 2020 оны жилийн эцсийн тооллого, ажлын үр дүнгээр бусдыгаа манлайлсан “Улсын сайн малчин”-1, “Аймгийн сайн малчин”-2, “Сумын сайн малчин”-18, шинээр төрсөн 14-н “Мянгат малчин”-ы шагналыг; Хөдөлмөр гавъяагаа үнэлүүлсэн салбар салбарын 10 иргэнд төрийн одон медалийг, 75 аас дээш насны 58 ахмад настанд аймаг сумын засаг дарга нарын бэлэг зэргийг тус тус гардуулж хүндэтгэл үзүүлсэн.

Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хилийн манааны агт уналгын тоог нэмэгдүүлж, хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нэг хот-Нэг агт” аяны хүрээнд ХХТХГ, хилийн зурваст нутаглах малчин өрхийн идэвхи санаачлагааар хот айлын зохион байгуулалтанд орж 46 тооны уналгын морь, 1,2-р багийн 6 малчин хилийн 3-р заставт Дроныг тус тус хандивлалаа.

Хил хамгаалахад туслах хүчний гишүүнээр элсэх хүсэлт гаргасан 28 гишүүнд үнэмлэх тэмдгийг олгож гэрээ байгууллаа.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хилийн зурваст нутаглаж буй байршлаараа хил хамгаалалтад оролцож, хилийн орчмын дэглэмийн биелэлтийг сахиулах, хяналт тавих зорилгоор хилийн зурваст нутагладаг ХХТХГ, орон нутгийн иргэдийг өөрсдийн хүсэлтийн дагуу “Малчдын бүлэг”-ийн зохион байгуулалтад оруулж 64 иргэнийг 9 бүлэгт хуваарилан бүлгийн дарга нарыг сонгож баталгаажууллаа.

Газар зохион байгуулалт: Сумын ИТХ-ын хуралдаанаар иргэдэд гэр бүлийн хэрэгцээнд зориулж шинээр 277 иргэнд 20.775 га, 0.45 га талбай бүхий газрыг төрөөс нөхөн олговортойгоор, төмс хүнсний ногоо тарих зориулалтаар 16 иргэнд 1.6 га, гэр бүлийн хамтын хэрэгцээнд төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар давуу эрхээр 1 иргэнд 0.8796 га, 6 иргэнд гэр бүлийн зориулалтаар 0.42 га газрыг эзэмшүүлэхээр;

Иргэн аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 2.365 га газрыг дуудлага худалдаагаар, хадлангийн зориулалтаар 24400 га газрыг ашиглуулах, төсөвт байгууллагын албан хэрэгцээнд 0.9524 га газрыг эзэмшүүлэх, 119 нэгж талбарыг өвөлжөө, хаваржааны доорхи газар зориулалтаар тус тус олгохоор тусгагдсан болно.

Сумын ИТХ-ын 2021.01.29-ний өдрийн хуралдаанаар УТХГН-ийн өргөтгөл-80112.873 га талбай бүхий газрыг, сумын отрын нөөц зориулалтаар-1102749.862 га талбай бүхий газрыг, хадлан тэжээлийн нөөц зориулалтаар - 82057.539 га талбай бүхий газрыг тус тус орон нутгийн тусгай хэрэгцээнд авлаа.

Мөн “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоосон.

“Ковид-19” цар тахлаас үүдэлтэй тулгамдсан асуудлуудыг даван туулах, арга зүй, хувилбар, оновчтой шийдлийг олох, улмаар Төрийн байгууллагууд, төрийн албан хаагчдын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж ажиллаж байна. Гамшигийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гамшгаас хамгаалах эрсдлийг бууруулах зардлыг 55.0 сая төгрөгөөр батлуулсан. Халдварт цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал өсөн нэмэгдэж байгаа нь санхүүгийн нөөцөд хүндрэл учруулах төлөвтэй байна. Түргэвчилсэн оношлуур 100 ширхэгийг 2.8 сая төгрөг, Халдвар хамгаалалын хувцас - 10.0 сая төгрөг, Тусгаарлах өрөөний бүсчилсэн хамгаалалтын вакум хаалт - 2.5 сая төгрөг, Сургалт сурталчилгаа, бичиг хэргийн зардал - 1.2 сая төгрөг, Пост эргүүл хяналтын шатахууны зардал - 2 сая төгрөг одоогийн байдлаар нийт 18.5 сая төгрөгийг зарцуулаад байна.

Зөвхөн сар шинийн өдрүүдийн пост, хяналт, эргүүл, түүний ариутгал, хамгаалалтад 2.0 сая ₮ зардал гаргалаа.

Хаваржилт: Сумын нутаг дэвсгэрт нийт 400498 толгой мал хаваржиж байна. Гадны 3 хот айлын бүртгэлтэй 1600 толгой мал хаваржиж байна. Хилийн зурвас нутагт 117 өрхийн 92.4 мянган мал, үүнээс бод 21.1, бог мал 71.3 мянган толгой мал өвөлжсөн. Өвөлжилт хүндэрч хөдөөгийн малчин өрхүүдээс сонгож сумын нөөцөөс 124 өрхөд 1875 боодол өвсийг 3500 төгрөгөөр үнэлэн олгосон.

ЕБС: Аймгийн засаг даргын захирамжийн дагуу ЕБС-ийн 1,2,5,9 дүгээр ангийн сурагчдад эцэг эхийн хүсэлтийг үндэслэн давтлага зохион байгуулж, давтлагыг эхлүүлээд байна. Давтлаганд нэг ангид 10 сурагч хамрагдаж байна. Бага анги- 13 бүлэг, дунд анги- 4 бүлэг үүсгэн ариутгал халдваргүйжүүлэлт хийж халдвар хамгааллын дэглэмийг чандлан мөрдөж ажиллаж байна.

ЭЕШ-ын давтлага хуваарийн дагуу хичээллэж байна. 7 төрлийн хичээлээр 19 багш давтлагыг хичээллүүлж байна. 5 анги тус бүрт 2 үйлчлэгч 2 цаг тутамд цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж байна. Сурагчдын ирэх болон явахад халууныг тогтмол үзэн гарыг ариутгаж бүртгэл хөтөлж байна. Нэг ангид доод тал нь тухайн хичээлээсээ шалтгаалан 4-5 сурагч дээд тал нь 10 сурагч хичээллэдэг. Нийгэм судлал хичээлийн хувьд 3 багш бэлтгэж байгаа бөгөөд нэг ангид 11 сурагч хичээллэж байна.

СӨБ: Теле хичээлийн тандалт судалгааг бүлгийн багш нар хийж хамрагдалтын хувийг гаргаж ажилласан. Үүнд: Ахлах бүлэг 28 хүүхэд, холимог бүлэг 32, бэлтгэл 36, нийт 96 хүүхэд буюу 73,8% тай хамрагдаж байна. Үлдсэн 34 хүүхэдтэй холбогдож чадаагүй болон ах эгч нарынх нь хичээлийн цаг давхцаж байгаа учраас үзэж чадахгүй байгаа зэрэг шалтгаанаар теле хичээлд хамрагдаж чадаагүй байна.

Бүлгийн багш нар теле хичээлийн хажуугаар бүлгүүдийн дотоод цахим группээр дамжуулан өөрсдийн бэлтгэсэн теле хичээлийг суралцагчдад хүргэж ажилласан. Нийт 5 багш 10 цахим хичээлийг боловсруулан хүргэсэн байна.

Хөдөлмөр халамж:ХБИ-91, ахмадын тэтгэвэр-11, ТАТ-57, бүгд 159 иргэний хувийн хэргийг баяжуулж бүртгэлээ. Сар шинээр олгодог төрийн харъяалалтай 427 ахмадыг АДЗ-өөр хэлэлцүүлэн хяналтын мэргэжилтэнд хүргүүлэн праграмд данс утасны дугааруудыг оруулсан.

Улсын бүртгэл: Төрсний бүртгэл 13, Гэрлэсний бүртгэл 3, Гэрлэлт цуцалсны бүртгэл 2, Үрчлэлтийн бүртгэл 0, Эцэг тогтоосны бүртгэл 4, Овог нэр өөрчилсний бүртгэл 0, Нас барсны бүртгэл 3, Лавлагаа 7 иргэнд, Шилжилт хөдөлгөөний бүртгэл 8, Цахим үнэмлэхний шинээр олголт болон сунгалтыг 11 иргэнд бүртгэл хийгдсэн байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар